



**НИЙСЛЭЛИЙН  
ӨМЧИЙН АШИГЛАЛТ, УДИРДЛАГЫН ГАЗРЫН  
ДАРГЫН ТУШААЛ**

2021 оны 09 сарын 14 өдөр

Дугаар А/276

Улаанбаатар хот

Баянзүрх дүүргийн “Нийтлэг үйлчилгээний”  
газар хоёр” ОНӨААТҮГ-ын данс бүртгэлээс  
тээврийн хэрэгсэл хасах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1 дэх хэсэг, 80 дугаар зүйл, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 66 дугаар тогтоолоор баталсан “Нийслэлийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн хөдөлгөөн, түүнтэй холбогдох бусад харилцааг зохицуулах журам”-ын 4 дүгээр зүйл, Нийслэлийн Засаг даргын 2021 оны А/614 дүгээр захирамжийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Техникийн комиссын дүгнэлтээр ашиглалтын шаардлага хангахгүй болсон, засаж сэлбэж ашиглах нь эдийн засгийн хувьд үр ашиггүй нь тогтоогдож, сэлбэгийн буюу хоёрдогч түүхий эдийн зориулалтаар татан төвлөрүүлж худалдахаар шийдвэрлэгдсэн нийт 388,457,800 (гурван зуун наян найман сая дөрвөн зуун тавин долоон мянга найман зуу) төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий тээврийн хэрэгслүүдийг хавсралтын дагуу данс бүртгэлээсээ хасахыг Баянзүрх дүүргийн “Нийтлэг үйлчилгээний газар хоёр” ОНӨААТҮГ (Ц.Ууганбаяр)-т зөвшөөрсүгэй.

2. Данснаас хасагдаж буй тээврийн хэрэгслийг Нийслэлийн Өмчийн ашиглалт, удирдлагын газарт актаар хүлээлгэн өгч, өмчийн мэдээллийн санд хөрөнгийн хөдөлгөөний холбогдох өөрчлөлт хийх, тээврийн хэрэгслийн гэрчилгээ улсын дугаарыг хураан авч авто тээврийн улсын бүртгэл, татварын бүртгэлээс хасуулахыг Баянзүрх дүүргийн “Нийтлэг үйлчилгээний газар хоёр” ОНӨААТҮГ (Ц.Ууганбаяр)-т үүрэг болгосугай.

3. Татан төвлөрүүлж буй хөрөнгийг худалдан борлуулах ажлыг зохион байгуулж, үр дүнг тайлагнахыг Захиргаа, санхүүгийн хэлтэс (Б.Батбаяр)-т, тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Орлогч дарга (Б.Болор-Эрдэнэ)-д тус тус даалгасугай.

ДАРГА



М.БАЯРАА

115050000809

Нийслэлийн Өмчийн ашиглалт, удирдлагын газрын  
 даргын 2021 оны 09 дугаар сарын 14-ний өдрийн  
 ..... А/276 ..... дугаар тушаалын хавсралт



Данснаас хасах тээврийн хэрэгслийн жагсаалт

д/д	Байгууллагын нэр	Автомашинны марк, улсын дугаар	Балансын үнэ	Хуримтлагдсан элэгдэл	Үлдэх өртөг
1		Тоёота корса 01-42 УНА	3,700,000.0	3,700,000.0	0.0
2		Хьюндай HD-120 05-02 УНП	100,777,800.0	100,777,800.0	0.0
3	Баянзүрх дүүргийн Нийтлэг үйлчилгээний газар хоёр ОНӨААТҮГ	Исузу 30-16 УБА	99,990,000.0	99,990,000.0	0.0
4		Исузу 31-26 УБА	99,990,000.0	99,990,000.0	0.0
5		Исузу 93-15 УБЕ	84,000,000.0	84,000,000.0	84,000,000.0
<b>Дүн</b>			<b>388,457,800.0</b>	<b>388,457,800.0</b>	<b>0.0</b>

/төгрөгөөр/